# ХИЛИЙН ТУСГАЙ АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТЭД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Г.Лхагвамаа
Аюулгүй байдлын удирдлага, стратегийн профессорын багийн профессор, доктор, дэд профессор, хурандаа
С.Пүрэв-Очир
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн магистрант, хошууч

***Товч агуулга:*** Хил хамгаалах байгууллагын тусгай албаны хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын өнөөгийн байдалд шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, судалгааны үр дүнг үндэслэн санал, зөвлөмжийг дэвшүүлэхийг зорилоо.

***Abstract:*** The purpose is to analyze the current state of human resource management and organization of the special services of the border protection organization, to identify ways to solve the problems, and to make suggestions and recommendations based on the results of the research.

***Түлхүүр үгс:*** Хил хамгаалах байгууллага, тусгай алба, хүний нөөцийн удирдлага зохион байгуулалт.

***Keywords:*** Border protection organization, special force, human resource management.

## Оршил

Хил хамгаалах байгууллагын тусгай хүчинд үүрэг гүйцэтгэх, Хил хамгаалах байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад үүргийг гүйцэтгэхэд албан хаагчдыг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл бүрдүүлэх зорилгоор тэдний гүйцэтгэж байгаа үүрэг, ур чадварт нийцсэн цалин хөлс, урамшууллын систем, хүний нөөцийн удирдлагын асуудлыг шийдвэрлэх, түүнчлэн алба хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Тусгай албанд ажиллаж байгаа алба хаагчдын ажиллах нөхцөл, хүний нөөцийн менежментийг сайжруулах үйл ажиллагааны чиглэл, Төрийн албаны болон бусад тогтоомжоор хамгаалагдсан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, арга замыг нэн тэргүүнд тодорхойлох нь зүйтэй юм.

Нийгмийн баталгаа хангагдсан алба хаагчдаас ажлын төлөө сэтгэл, ур чадвар, идэвх зүтгэл бүрэн дүүрэн гарах бөгөөд Хил хамгаалах байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

## Нэг.Хууль сахиулах байгууллагын тусгай албаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа

Монгол Улсад хүчний байгууллага, цэрэгжсэн байгууллага гэх албан бус ойлголтууд хэрэглэгдэж, олон нийтийн дунд тус байгууллагын үйл ажиллагаа, чиг

үүргийг ялгаж ойлгохгүй байгаа, нөгөө талаар хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулсан хуулийн багц төслийг УИХ-д өргөн барьж, хууль сахиулах салбарын албан хаагчийн эрх зүй, нийгмийн баталгаа, ёс зүйг олон улсын стандартад нийцүүлж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах төрийн албан хаагчийн үйл ажиллагаа байгууллагаас бус хуулиас илүү хамааралтай байх нөхцөлийг бүрдүүлж, албан үүргээ гүйцэтгэх, ажиллах баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зэрэг олон тулгамдсан асуудлаар хуулийн шинэчлэлийг хийж байгаа билээ.

Хууль сахиулах байгууллагын тусгай албаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндэс нь төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, дотоодын цэрэг, хил, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар тодорхойлогдож байна.

Дээрх зохицуулалтын хүрээнд тусгай албаны талаар тайлбар нэр томьёог судалж үзэхэд Тадаадын тусгай алба” тодорхойлсон хэм хэмжээ байна. **“Гадаадын тусгай алба”** гэж тагнуулын үйл ажиллагаа, эсхүл тагнуулын үйл ажиллагааны тодорхой чиг үүргийг хэрэгжүүлдэг гадаад улсын байгууллага, түүний салбар, нэгжийг хэлнэ. [1]

Хүний нөөцийн менежментийн үндсэн зорилго бол ажилтан бүрийн авьяас чадвар, нөөц боломжуудыг нээн илрүүлж хөгжүүлэх, хүмүүсийг санаачлагатай ажиллахад уриалан дуудах, өмнөө тавьсан зорилгоо биелүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх орчин нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Байгууллагад хүний нөөцийн менежмент нь ажилтныг ажилд авахаас эхлээд халах хүртэл олон талт, өргөн хүрээ бүхий дараах үүргийг гүйцэтгэдэг: хүмүүсийг цуглуулах, сонгох, ажилд авах, сонгох ба аттестачлах үед ажилтны ажил хэргийг үнэлэх, шинэ ажилтныг чиглүүлэх ба дасан зохицуулах, ажилчдийн хөдөлмөрийн үйл ажиллагааг идэвхжүүлж, урамшуулах, өдөөх, хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах ба ажил хэрэгч харилцааны ёс зүйг хангах, ажиллагчдын мэргэжил дээшлүүлэх ба дахин бэлтгэх, карьер хөгжил ба ажил сэлгэлтийн удирдлага, байгууллага дах ажилтны зан төлөвийг удирдах, нийгмийн хөгжлийн удирдлага, ажлаас чөлөөлөх гэх мэт болно.

Орчин үеийн олонх байгууллагад хүний нөөцийн менежмент зөвхөн өөрсдийн ажиллагчдын асуудлыг удирдан зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаа биш, харин ирээдүйд байгууллагын ажиллах хүмүүсийг удирдах асуудлыг хамрах болж байгаа билээ.

Хүний нөөцийн менежментийн функцуудыг дараах байдлаар ангилдаг.Үүнд:

- Хүний нөөцийн менежментийн чиг үүргүүд
- Хүний нөөцийг бүрдүүлэх

[1] Тагнуулын байгууллагын тухай хуулийн 3.1.3 дэх зүйл.Төрийн мэдээлэл 1999.№35

- Хүний нөөцийг хөгжүүлэх
- Цалин шагнал урамшуулал гэх мэт функуудаас бүрддэг.[2]

**Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн дүрэм.**

Үндэсний аюулгүй байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалахад боловсрол, мэргэжлийн чадвар, бие бялдар, эрүүл мэнд, ёс зүйн хүмүүжил, сэтгэл зүйн бэлтгэлээр шаардлага хангахуйц албан хаагчдыг сонгож, бэлтгэх нь Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлогын үндсэн чиглэл байна.[3]

Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааны шалгуур нь хууль тоггоомжийн хэрэгжилт, албан хаагчийн хөдөлмөрийн бүтээмж, тогтвор суурьшил, сэтгэл ханамжийн байдал, хөдөлмөрийн маргаан, гомдол гаргасан байдал, улсын хил хамгаалалтын эцсийн үр дүнгээр хэмжигдэнэ.

**Хилчдийн нийгмийн хамгаалал 2024 хөтөлбөрт:** Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ажиллах, амьдрах ахуй нөхцлийг сайжруулж, тэдний эрүүл мэнд, хөгжлийн асуудлыг дээшлүүлж, өрхийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 3 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.[4]

Нийгмийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн тусгай, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, дотоодын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг тухайн хууль сахиулах байгууллагуудын хуулиар тогтоогдож байна.[5][6][7][8][9]

Хил хамгаалах байгуулагын тусгай албанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын цалин хөлсний нэмэгдэл, бусад нэмэгдлүүдийн талаар судлаж үзэхэд.Үүнд:

**1.Цалин хөлс, нэмэгдэл.**

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд ажилтны цалин хөлсийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох” тухай тогтоолын 3 дугаар хавсралт, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2, 51 дүгээр зүйлийн 51.1.4, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигийн 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Цэргийн Сахилгын дүрэм”-ийн 11 дүгээр зүйлийн 11.2.3, 32 дугаар

[2] Ц.Цэцэгмаа “Хүний нөөцийн менежмент” УБ.2014.16 дахь тал

[3] ХХЕГ-ын даргын 2021 оны А/16 дугаар тушаалын хавсралт

[4] Хилчдийн нийгмийн хамгаалал 2024 хөтөлбөр

[5] Дотоод цэргийн тухай хуулийн 36 дугаар зүйл. Төрийн мэдээлэл 2017.№12

[6] Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйл.Төрийн мэдээлэл 2017.№7

[7] Цагдаагийн тухай хуулийн 86 дугаар зүйл.Төрийн мэдээлэл 2017.№8

[8] Шүүхийн тухай хуулийн 88 дугаар зүйл. Төрийн мэдээлэл 2017.№24

[9] Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйл Төрийн мэдээлэл 2017.№6

зүйлийн 32.3 дахь заалтын дагуу тус тус нэмэгдүүлэх болон бууруулахад албан тушаалын тухайн сарын үндсэн цалинтай уяж тооцож байна.

Алба хаагчдын цалин, хангамжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх нь хүний нөөцийн удирдлага хангагдах чухал хөшүүрэг юм.

Төрийн тусгай алба хаагчдын цалингийн нэмэгдэл, урамшууллын талаар цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд "цолны нэмэгдэл", "зэвсэгт хүчин, "хилийн цэргийн офицер", "ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацаа", "онцгой нөхцөлийн нэмэгдэл", "төрийн болон албаны нууц хариуцан ажилласны нэмэгдэл", "хилийн нэмэгдэл", /ХХЕГ-ын даргын 2018 оны А/261 дүгээр тушаал/, "спортын зэрэг цолны нэмэгдэл", ХХБ-ын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчдад цэргийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл /ХХЕГ-ын даргын 2020.02.07 А/11 дугаар тушаал/[10], унаа, хоолны хөнгөлөлт олгох тухай /ХХЕГ-ын даргын 2018.09.03 А/177 дугаар тушаал/, улсын хилд 5-аас дээш хугацаагаар алба хааж буй офицер, ахлагчид нэг удаагийн урамшуулал олгох тухай /ХХЕГ-ын даргын 2017.11.10 А/255 дугаар тушаал/-уудыг тус тус мөрдөж ажиллаж байна.

**2.Бусад нэмэгдэл.**

Спортын мастерийн нэмэгдэл:
Биеийн тамир спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтыг үндэслэн Хилийн 0208 дугаар тусгай салбар /Хилчин спорт хороо/-т тухайн чиглэлийн албан тушаалд ажиллаж буй спортын цолтой тамирчин, албан хаагчид албан тушаалын үндсэн цалингаас нь 10 хүртэл хувиар тооцон олгож байна.[11]

Хоол унааны нэмэгдэл: Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2018 оны 09 дүгээр сарын 03-ны А/177 дугаар тушаалын дагуу тооцддог.

**Төрийн тусгай алба хаагч болон тусгай хүчний алба хаагчдын цалин, нэмэгдлийн харьцуулсан судалгаа.**

Нийгмийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй цагдаа, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын албан хаагчийн эрх зүйн байдлыг тухайн салбарын хуулиар зохицуулан хэрэгжүүлж байгаа боловч, тэр нь харилцан адилгүй байна.Үүнд:

Цагдаа, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын албан хаагчдын төрийн тусгай алба хаасны нэмэгдэл, эрх зүйн баталгаа нь харилцан адилгүй, зөрөөтэй байгааг дараах хүснэгтээр харуулав.

[10] Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл.Төрийн мэдээлэл 2016. №36

[11] Биеийн тамир спортын тухай хуулийн 22 дугаар зүйл. Төрийн мэдээлэл 2017.№43

**Хүснэгт 1.Төрийн тусгай алба хаасны нэмэгдлийн харьцуулалт**

| Цагдаа | | Шүүхийн шийдвэр | | Хилийн цэрэг | | Онцгой байдал | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЗГ-ын 2014 оны 99-р тогтоол | | ЗГ-ын 2011 оны 189-р тогтоол | | ЗГ-ын 2000 оны 2-р тогтоол | | ЗГ-ын 2005 оны 77-р тогтоол | |
| Алба хаасан жил | Нэмэгдэл | Алба хаасан жил | Нэмэгдэл | Алба хаасан жил | Нэмэгдэл | Алба хааса н жил | Нэмэгдэл |
| 11-17 | 15 хувь | 15-19 | 15 хувь | 15-19 | 15 хувь | 15-19 | 15 хувь |
| 18-24 | 20 хувь | 20-24 | 20 хувь | 20-24 | 20 хувь | 20-24 | 20 хувь |
| **25** жилээс дээш **45 хувь** | | **31** жилээс дээш ажилласан бол **30 хувь** | | | | | |

**Хүснэгт 2. Онцгой байдлын нэмэгдлийн харьцуулалт**

| Цагдаа | | Шүүхийн шийдвэр | | Хилийн цэрэг | Онцгой байдал |
|---|---|---|---|---|---|
| ЗГ-ын 2014 оны 99-р тогтоол | | ЗГ-ын 2001 оны 189-р тогтоол | | ЗГ-ын 2004 оны 123-р тогтоол | |
| 1-р зэрэг | **25** хувь | 1-р зэрэг | **20** хувь | 10 хувь | 30 хувь |
| 2-р зэрэг | **20** хувь | 2-р зэрэг | **15** хувь | | |
| 3-р зэрэг | **15** хувь | 3-р зэрэг | 10 хувь | | |

**Хүснэгт3.Тусгай хүчний албан хаагч, албан тушаалтнуудын үндсэн цалин, нэмэгдлийг харьцуулсан судалгаа**

| д/д | Байгууллагын нэр | Албан тушаал | Цалингийн нэмэгдлүүд | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Цалин шатлал | Цолны нэмэгдэг | ТТАХХн | Онцгой нөхцөл | Спортын зэрэг | *Хамгаалалтын нэмэгдэл* | *Нийт дүн* |
| 1 | Хилийн 0303 дугаар тусгай салбар | Төлөвлөлт, бэлэн байдлын тасгийн дарга | ТТ-12-3 819842 | 32 262349 | 8 65587 | 10 81984 | - | - | 1.229.765 |
| | | Холбоочин буудагч | ТТ-7-2 634736 | 22 139641 | 5 31736 | 10 63473 | - | - | 869.586 |
| 2 | Цагдаагийн | Бүлгийн дарга | ТТ-13-3 853706 | 30 256111 | 25 213426 | 25 213426 | 5 42685 | **-** | 1.579.354 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тусгай ажиллагааны газар | Цагдаа | ТТ-8-2 659346 | 25 164836 | 8 52747 | 25 164836 | 5 32967 | | 1.074.732 |
| 3 | Төрийн тусгай хамгаалалтын газар | Залбарын хамгаалалтын албаны салбарын дарга | ТТ-12-3 1099842 | 32 351949 | 8 87987 | - | - | 5-20 219968 | 1.759.746 |
| | | Хамгаалалтын дэд ажилтан | ТТ-6-2 861298 | 22 189485 | 5 43064 | - | - | 5-20 172259 | 1.266.106 |

*Тайлбар: Судалгааг бодитой гаргахын тулд тасгийн дарга нарыг ахмад цолтой төрийн байгууллагад 10 жил ажилласан, холбоочин буудагч, ахлагч цолтой төрийн байгууллагад 5 жил ажилласан алба хаагч нарт судалгаа хийсэн болно.*

**Хүснэгт 4.Төрийн тусгай алба хаагч, албан тушаалтнуудын хоол, унааны нэмэгдлийн талаар харьцуулсан судалгаа**

| д/д | Байгууллагын нэр | Унаа, хоолны нэмэгдэл | | |
|---|---|---|---|---|
| | | Унаа 1 өдөр | Хоол 1 өдөр | Унаа, хоолны нэмэгдэл нийт сараар |
| 1 | Хилийн 0303 дугаар тусгай салбар /ХХЕГ-ын даргын 2018.09.03 А/177 | 2000 | 3000 | 100.000 |
| 2 | Гал түймэр унтраах аврах 10 дугаар анги | 3000 | 5000 | 160.000 |
| 3 | Хан-Уул дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтэс /ЦЕГ-ын даргын 2021.04.22 А/114 | Нийтийн тээврээр албаны үнэмлэхээрээ үнэгүй үйлчлүүлдэг | 8000 | 160.000 |

*Тайлбар: Унаа, хоолны мөнгийг ажлын 20 хоногоор тооцож, бусад байгууллагын дүнтэй харьцуулахад сард 60.000 мянган төгрөгийн зөрүү гарч байна.*

Дээрх цалингийн харьцуулсан судалгаанаас үзэхэд тусгайлсан чиг үүргийн байгууллагуудын цалин манай салбарын цалингаас 400.000-530.000 мянган төгрөгөөр илүү байгаа тул зөрүүг арилгаж дээрх байгууллагуудын цалингийн

жишигт хүргэвэл алба хаагчдын хүний нөөцийн удирдлагын цалин, шагналын үйл ажиллагаа хангагдана.

**Хоёр.ХХБ-ын тусгай албаны хүний нөөцийн менежментэд тулгамдаж буй асуудал шийдвэрлэх арга зам**

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан хуулийн багц төслийг УИХ-д өргөн барьж, хууль сахиулах салбарын эрх, үүрэг, ёс зүйг олон улсын стандартад нийцүүлж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, төрийн албан хаагчийн үйл ажиллагаа байгууллагаас бус хуулиас илүү хамааралтай байх нөхцөлийг бүрдүүлж, албан үүргээ гүйцэтгэх, ажиллах баталгааг хангахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулж байна

Нийгмийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй цагдаа, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын албан хаагчийн эрх зүйн байдлыг тухайн салбарын хуулиар хэрэгжүүлж байгаа боловч, тэр нь харилцан адилгүй байна.Үүнд:

-Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын цалин хөлс, нэмэгдлийн судалгаанаас авч үзэхэд Хил хамгаалах байгууллагын тусгай албаны алба хаагчдын ур чадвартай, дадлага туршлагатай, бэлтгэгдсэн алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах гол хүчин зүйлийн нэг болох цалин хангамж, тусгай албанд ажилласан жилийн нэмэгдэл нь хилийн отряд, анги төдийгүй зарим адил чиг үүрэгтэй хүчний байгууллагуудын алба хаагчдынхаас бага байна.

- Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2020 оны А/36 дугаар тушаалын 5.87 дэх хэсэг хилийн 0208 дугаар тусгай салбар /Хилчин спорт хороо/-аас бусад хилийн анги, тусгай салбарын захирагч нар спортын зэргийн нэмэгдлийг тушаал гаргаж олгохыг хориглосон.

- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 22.5 дахь заалт Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгжид ажилласан алба хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно гэсэн зохицуулалтыг Хил хамгаалах байгууллагын тусгай албаны цэргийн алба хаагч тооцохгүй явж ирсэн хүний нөөцийн менежментэд тулгамдсан асуудал болж байна.[12]

- Сүлдэт шонхор, ногоон берет гэм мэт зөвхөн тусгай албаны онцлогт тохирсон мэргэжлийн зэрэг олгох журмаар олгох нэмэгдэл /Цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа тусгай чиг үүргийн нэгжүүдэд мөрдөгддөг/

- Унаа, хоолны нэмэгдлийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

[12] Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйл Төрийн мэдээлэл 2017.№41

**Хүснэгт 5.Хилийн тусгай албанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдаас санал, асуулга, судалгаа авахад дараах байдлаар тогтоогдсон.**




*Эх сурвалж:Хилийн 0303 дугаар тусгай салбарын бие бүрэлдэхүүнээс авсан социологийн судалгаа 2021 он*

*Тайлбар: Хилийн тусгай албанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдаас судалгаа явуулахад оролцогчдын 60 хувь цалин хөлс нэмэгдүүлэх, 20 хувь нь хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээл, түрээсийн орон сууцад хамрагдах, 5 хувь нь, 5 хувь нь томилолтын зардал шийдвэрлүүлэх, тусгай хүчний нэмэгдэл цалин, тусгай албанд ажилласан хугацааны нэмэгдэл тооцох, тусгай ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үеийн амь насны даатгалд хамрагдах гэж судалгаанд хариулсан байна.*

Энэ байдлаас шалтгаалан ур чадвартай, дадлага туршлагатай бэлтгэгдсэн алба хаагчид хилийн отряд, анги, бусад хүчний байгууллагад шилжин ажиллах нь цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.Энэ нь ХХБ-ын хүний нөөцийн менежментэд тусгай албаны тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж болохыг харуулж байна.

**Дүгнэлт**

Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын цалин хөлс, нэмэгдлийн судалгаанаас авч үзэхэд Хил хамгаалах байгууллагын тусгай албаны алба хаагчдын гол хүчин зүйлийн нэг болох цалин хангамж, тусгай албанд ажилласан жилийн нэмэгдэл нь хилийн отряд, анги төдийгүй зарим адил чиг үүрэгтэй хүчний байгууллагуудын алба хаагчдынхаас бага байгаа нь судалгаагаар тогтоогдож байна.

Төрийн тусгай алба хаагчдын нийгэм хамгаалал, эрх зүйн баталгаа нь хууль, эрх зүйн хүрээнд зохицуулалт нь бүрдсэн боловч цалин хөлс, урамшуулалт нь тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд харилцан адилгүй байна.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт “Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгжид ажилласан алба хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно.” гэсэн заалт Хил хамгаалах байгууллагын тусгай албаны алба хаагчдад одоогоор үйлчлэхгүй байна.

**Санал**

Дээрх хуулийн хэрэгжилтийг хангахад ХХБ-ын тусгай албаны удирдлага зохион байгуулалтад тулгамдаж буй дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

**Нэг.Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:**

- *Засгийн газрын түвшинд:* ХХЕГ-ын харьяа хилийн 0303 дугаар тусгай салбарыг/тусгай анги / болгох саналыг өргөн барих;

- Биеийн тамир спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтыг үндэслэн хилийн тусгай албанд тухайн чиглэлийн албан тушаалд ажиллаж буй спортын цолтой, албан хаагчид албан тушаалын үндсэн цалингаас нь 10 хүртэл хувиар тооцон олгох ажлыг хэрэгжүүлэх.

**Хоёр.Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:**

- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт “Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгжид ажилласан алба хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно.” гэсэн заалтыг Хил хамгаалах байгууллагын тусгай албаны алба хаагчдад олгуулах;

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 22.1 дэх хэсэгт “Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцохоор томилогдсон зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай бэлтгэл, зориулалт бүхий нэгжийн алба хаагчийг гэнэтийн осол, амь насны даатгалд заавал хамруулах.

**Эх сурвалжийн жагсаалт**


- Тагнуулын байгууллагын тухай хууль.Төрийн мэдээлэл 1999 он №35
- Дотоод цэргийн тухай хууль. Төрийн мэдээлэл 2017 он

-Гамшгаас хамгаалах тухай хууль.Төрийн мэдээлэл 2017 он

-Цагдаагийн тухай хууль.Төрийн мэдээлэл 2017 он .№8

- Шүүхийн тухай хууль. Төрийн мэдээлэл 2017 он №24

- Хилийн тухай хууль Төрийн мэдээлэл 2017 он .№6

- Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль.Төрийн мэдээлэл 2016 он №36

- Биеийн тамир спортын тухай хууль. Төрийн мэдээлэл Төрийн мэдээлэл 2017 он №43

- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль УБ 2019 он Төрийн мэдээлэл 2017 он №41

-Ц.Цэцэгмаа “Хүний нөөцийн менежмент” УБ 2014 он

- ХХЕГ-ын даргын 2021 оны А/16 дугаар тушаалын хавсралт

- ’’Шинжлэх ухаан практикийн анхаарал татсан асуудлууд” УБ 2013 он

- ’’Менежмент сурах бичиг” /3 дахь хэвлэл/ УБ 2009 он

- ’’Хууль сахиулах үйл ажиллагаа, онол практикийн тулгамдсан асуудал" олон улсын эрдэм шинжилгээний хурал эмхэтгэл 1

- ”Хил хамгаалах байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” УБ 2020 он

**Цахим эх сурвалж:**

-http://www.legalinfo.mn/annex/
-http://www.legalinfo.mn
-Menejment.blog.gogo.mn